



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 4/73.

Мандалговь

Улсын аварга малчин өрх, аварга  
саальчинд олгох шагналд хөрөнгө  
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалт, "Улсын аварга малчин өрх, Улсын хошой аварга малчин өрх, Улсын аварга саальчин, Улсын аварга фермер, Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч шалгаруулах тухай" Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 32 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 5 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмж, малын үүлдээрлэг байдал чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлж, мал маллагааны уламжлалт аргыг боловсронгуй болгосон амжилтаараа шалгарч улсын аварга малчин өрх, саальчин цол хүртсэн малчдад хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах нийт 2,144,100 (хоёр сая нэг зуун дөчин дөрвөн мянга нэг зуун) төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Зардлын төрлийг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



481210247